



ДОТООД АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН СЭДЭВ: СЭЛЭНГЭ АЙМГИЙН ТҮШИГ СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2024 ОН, 2025 ОНЫ
ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН

АУДИТЫН КОД: ДА-2025/05/ҮА-ТТЗ

Сүхбаатар сум 2025 он	Санхүүгийн хяналт, дотоод аудитын газар Цахим хуудас: selenge@sankhuuaudit.se.gov.mn Дотоод аудитор: Г.Дорждэрэм Холбоо барих утас: 7036-8811 Цахим хаяг: Dorjderem@sankhuuaudit.se.gov.mn
--------------------------	--

Энэхүү дотоод аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ, СТАНДАРТЫН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ

<p>Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:</p>	<p>Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйл, 14.2.10, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2, 7 дугаар зүйлийн 7.4 дэх хэсэг, “Дүрэм батлах тухай” Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Дотоод аудитын дүрэм”, Дотоод аудитын хорооны 2025 оны 1 дүгээр тогтоолоор батлагдсан 2025 оны хяналт шалгалтын төлөвлөгөөний дагуу гүйцэтгэлээ.</p>
<p>Аудитын зорилт:</p>	<p>Түшиг сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн засаглал, эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын үйл явцуудын үр нөлөөтэй байдлыг үнэлж дүгнэх, тус байгууллагын үйл ажиллагааг сайжруулахад чиглэсэн зөвлөгөө өгөх замаар байгууллагын үнэ цэнийг нэмэгдүүлэх зорилготой.</p>
<p>Аудитын хамарсан хүрээ:</p>	<p>Түшиг сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 он, 2025 оны эхний хагас жилийн төсөв, санхүү, үйл ажиллагааны баримт материалыг хамруулав.</p>
<p>Аудитын арга зүй:</p>	<p>Дотоод аудитын мэргэжлийн практикийн Олон улсын стандарт, Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор баталсан “Дотоод аудитын дүрэм”, Монгол улсын сангийн сайдын 2019 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 268 дугаар тушаалаар батлагдсан “Улсын салбарын дотоод аудитын аргачлал”-ын дагуу аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох баримтыг цуглуулж, баримтжуулан, тэдгээрийг нягтлан шалгах, дүн шинжилгээ хийх, харьцуулалт, түүвэрлэлт зэрэг судалгааны арга зүйг ашиглан аудитын дүнд суурилан дүгнэлт өгч, зөвлөмж боловсрууллаа.</p>
<p>Аудитын шалгуур, үзүүлэлт:</p>	<p>Аудитад асуудлын шинжилгээний асуултын дагуу нарийвчлан боловсруулсан аудитын арга зүй, хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой дараах хууль, эрх зүйн актын холбогдох заалтыг шалгуур үзүүлэлт болгон ашиглалаа. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Авлигын эсрэг хууль • Иргэний хууль • Ашигт малтмалын тухай хууль • Төрийн албаны тухай хууль • Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль • Төсвийн тухай хууль • Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль • Хөдөлмөрийн тухай хууль • Төрийн хэмнэлтийн тухай хууль • Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль • Татварын ерөнхий хууль • Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам • Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам • Хоршоо хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам • УСННББОУС болон бусад стандартууд • Байгууллагын хөдөлмөрийн дотоод журам • Байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг • Бусад хууль, эрх зүйн актууд

НЭГ. ТАНИЛЦУУЛГА

Сэлэнгэ аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын 2025 оны нэгдсэн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу аймгийн Засаг дарга бөгөөд Төсвийн Ерөнхийлөн Захирагчийн 2025 оны 7 дугаар сарын 30-ны өдрийн ДА-2025/05/ҮА-ТТЗ дугаар удирдамжийн хүрээнд Сэлэнгэ аймгийн Түшиг сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн үйл ажиллагаанд дотоод аудитыг хийж гүйцэтгэлээ.

Дотоод аудитыг Засгийн газрын 483 дугаар тогтоолоор баталсан “Дотоод аудитын дүрэм”-ийг тус тус үндэслэн санхүүгийн хяналт шалгалт, эрх зүйн нийцлийн чиглэлээр хийж хэрэгжүүлсэн ба 2024 он, 2025 оны эхний хагас жилийн санхүү, төсөв, үйл ажиллагааны явцыг хамруулан, дахин тооцоолох, тулган шалгах хяналтын горимыг ашиглах, холбогдох ажилтнуудтай ярилцах, дотоод хяналтын орчныг судлах, үнэлэх, ажил гүйлгээг батлах, хянах, бүртгэх, тайлагнах процессын эрсдэлийг үнэлэх, мөрдвөл зохих хууль тогтоомжийн зүйл, хэсэг, заалтын хэрэгжилтийн байдлыг бодитоор илэрхийлж тогтоох, зорилгод хүрсэн түвшин, хүлээн зөвшөөрөгдсөн байдал, практикт нийцэж байгаа байдлыг шалгуур үзүүлэлтээр тодорхойлж ажиллав.

ХОЁР. АУДИТЫН ЗОРИЛГО, ЦАР ХҮРЭЭ

2.1 Аудитын зорилго:

Түшиг сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн засаглал, эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын үйл явцуудын үр нөлөөтэй байдлыг үнэлж дүгнэх, тус байгууллагын үйл ажиллагааг сайжруулахад чиглэсэн зөвлөгөө өгөх замаар байгууллагын үнэ цэнийг нэмэгдүүлэх зорилготой.

2.2 Аудитын хамрах хүрээ, хязгаарлалт

Түшиг сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн удирдлага зохион байгуулалтын засаглал, эрсдэлийн удирдлага болон дотоод хяналтын үйл явцыг үнэлэх;

Аудитаар тус газрын 2024 он, 2025 оны эхний хагас жилийн төсөв, санхүү, үйл ажиллагааг хамруулна. Үүнд:

- Байгууллагын засаглал, эрсдэлийн удирдлагын үйл явцыг үнэлэх;
- Төсвийн орлогын бүрдүүлэлт, санхүүжилт, хуваарилалт, үр дүн
- Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний үр дүн
- Орон нутгийн хөгжлийн сангийн бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн
- Хоршоог хөгжүүлэх сангийн бүрдүүлэлт, зарцуулалт үр дүн
- Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгэ худалдан авах тухай хууль тогтоомжийн хэрэгжилт
- Төсвийн төвлөрүүлэн захирагчийн дотоод хяналтын үр нөлөө
- Өмнөх хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлын арилгах арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байдал

Дотоод аудитын хамрах хүрээний хязгаарлалт:

Төрийн аудитын газраас Сэлэнгэ аймгийн Түшиг сумын төсвийн төвлөрүүлэн

захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг 9.4 хувиар буюу 77,599.2 мянган төгрөгөөр тасалсан зөрчилд төсвийн орлогын төвлөрүүлэх үр нөлөө бүхий арга хэмжээ авч, орлогыг бүрэн төвлөрүүлж байх албан шаардлага хүргүүлсэн байна.

Мөн Төрийн аудитын газраас “Орон нутгийн төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн” сэдэвт аудитыг 2025 оны 6 дугаар сард хийсэн байна. Аудитаар тус сумын ОНХС-ын үйл ажиллагаанд дараах албан шаардлага, зөвлөмжийг хүргүүлсэн байна. 2024 онд ОНХС-д 912.5 сая төгрөгийн төсөв батлагдаж 696.4 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байна.

2024 онд ИТХ-аар нийт 21 төсөл, арга хэмжээг батлуулснаас:

- 11 төсөл (52.4%) бүрэн хэрэгжсэн
- 1 төсөл (4.8%) дутуу хэрэгжсэн
- 9 төсөл (42.8%) огт хэрэгжээгүй байна

Хяналт шалгалтын хүрээнд 585,636.1 мянган төгрөгийн 5 зөрчил илэрснээс хариуцлага тооцох албан шаардлага 1, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага 2, зөвлөмж 2-г тус тус өгсөн байна. Үүнд:

Хариуцлага тооцох албан шаардлага

- Өмнөх аудитаар өгсөн шаардлагыг хэрэгжүүлээгүй, “Хогийн цэгийн хашаа барих”, “Нийтийн эзэмшлийн тохижилт” зэрэг 191.0 сая төгрөг ТАХ-ны зураг, төсвийг сумын ИТХ-аар батлуулсны дараа 2024 онд хийлгэсэн

Зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага

- “ЗДТГазарт автомашины гарж барих” ТАХ-нд ИТХ-аас батлагдсан дүнгээс 5,796.8 мянган төгрөгийн илүү санхүүжилт олгосон. Үүнд: Зохиогчийн хяналтын дүгнэлтгүйгээр зохиогчийн хяналтын зардалд 796.8 мянган төгрөг, зураг төсвийг хүлээж авсан актгүйгээр зураг төсвийн зардалд 5,000.0 мянган төгрөг тус тус олгосон байна.
- ОНХС-ийн УМС-д хавсралт 332.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 11 ТАХ-ны мэдээллийг огт оруулаагүй.
- “ЗДТГазарт автомашины гарж барих” ТАХ-нд ИТХ-аас батлагдсан дүнгээс 5,796.8 мянган төгрөгийн илүү санхүүжилт олгосон. Үүнд: Зохиогчийн хяналтын дүгнэлтгүйгээр зохиогчийн хяналтын зардалд 796.8 мянган төгрөг, зураг төсвийг хүлээж авсан актгүйгээр зураг төсвийн зардалд 5,000.0 мянган төгрөг тус тус олгосон байна.
- ОНХС-ийн УМС-д хавсралт 332.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 11 ТАХ-ны мэдээллийг огт оруулаагүй.

Зөвлөмж

- ОНХС-ийн чиг үүрэгт хамаарахгүй удирдлагын хэрэгжүүлэх “ЗДТГазарт автомашины гарж барих” гэсэн төсөл арга хэмжээг төлөвлөж, санхүүжүүлсэн
- Шилэн дансны мэдээлэл оруулахдаа 61 мэдээлэл зөрүүтэй мэдээлсэн байна.

Иймд ТТЗ-ын 2024 оны хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээнд аудит хийгдээгүй болно.

Аудитын явцад хязгаарлалт тогтоохгүй, шинж чанарын үүднээс цааш нь нарийвчилсан горим сорил хэрэгжүүлж болно.

2.3 Аудитын арга, аргачлал

Дотоод аудитын мэргэжлийн практикийн Олон улсын стандарт, Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор баталсан “Дотоод аудитын дүрэм”, Монгол улсын сангийн сайдын 2019 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 268 дугаар тушаалаар батлагдсан “Улсын салбарын дотоод аудитын аргачлал”-ын дагуу үйл ажиллагааны эрсдэлийг үнэлэн албан тушаалтнаас асуулга тодруулга авах, нотлох зүйлсийг нягтлах, тулган баталгаажуулах, дүн шинжилгээ хийх горимуудыг ашиглав.

2.4 Аудитын хугацаа, бүрэлдэхүүн

Дотоод аудитыг 2025 оны 08 дугаар сарын 30-ны өдрөөс 2025 оны 09 дугаар сарын 12-ны өдрийг хүртэлх хугацаанд Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын дарга СХШАУБ Т.Одсүрэн ахалж, дотоод аудитор Г.Дорждэрэм гүйцэтгэв.

ГУРАВ. БАЙГУУЛЛАГЫН САЙН ТУРШЛАГА, ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА, ДОТООД ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО

3.1 Байгууллагын сайн туршлага

Түшиг сумын удирдлагын баг болоод төрийн албан хаагч нар тогтвор суурьшилтай ажилладаг тул төрийн үйл ажиллагааг тасралтгүй явуулахад ямар нэгэн саад бэрхшээл тулгардаггүй байна. Тус суманд шилжин суурьшиж ажиллаж байгаа төрийн албан хаагчдыг дэмжих зорилгоор аж ахуйн нэгжийн дэмжлэгтэйгээр мөнгөн тэтгэмж олгодог бөгөөд 2024-2025 онд 4 төрийн албан хаагчид 4,0 сая төгрөгийн тэтгэмж олгож, амьдрах байраар хангасан байна.

Мөн Түшиг сум нь аймгийн төв болоод Улаанбаатар хоттой хатуу хучилттай замаар холбогдсон сүүлийн жилүүдэд хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, газар тариаланг шинэ шатанд хөгжүүлэх зорилго тавьсан байна. Энэ хүрээнд 2025 онд “Ариун агро” ХХК-тай хамтран Халимаг үүлрийн цөм сүрэг, Увс аймгийн Малчин сумын “Увс хар азарга” хоршоотой хамтран “Баяд” үүлдрийн цөм сүргийг бүс нутагт өсгөн үржүүлэх ажлыг эхлүүлсэн байна.

Тус суманд үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж байгууллагуудтай хамтран нийгмийн хариуцлагын хүрээнд “Гудамж төсөл”-ийг, “Нутгийн оюутан” хөтөлбөрийг хэрэгжүүлсэн байна.

3.2 Засаглалын талаар

Сэлэнгэ аймгийн Түшиг сумын удирдлагын багт ИТХ-ын даргаар С.Түвшинбаяр, Засаг даргаар Н.Барамсай нар 2024 оны орон нутгийн сонгуулийн үр дүнгээр томилогдсон байна. Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт 89 хувь, 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт 2025 оны эхний хагас жилийн байдлаар 80 хувь, аймгийн Засаг даргатай хамтран ажиллах гэрээний биелэлт 2024 онд 89 хувь, 2025 онд 80 хувь, Хууль, тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт 2024 онд 80 хувь, 2025 онд 87.1 хувь, аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөний биелэлт 2024 онд 82, 2025 онд 84.6 хувь, “Аялал жуулчлал-ногоон хөгжлийг дэмжих жил”-ийн ажлын төлөвлөгөөний хэрэгжилт 2024 онд 82.9 хувьтай хэрэгжүүлсэн байна.

Засаглах удирдлага, гүйцэтгэх удирдлагын хооронд эрсдэл, хяналтын талаар мэдээлэл солилцдог.

Сумын Засаг дарга Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын хууль тогтоомж, Засгийн газрын бодлого шийдвэр, аймаг, сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг нийгмийн зорилтын хэрэгжилтийг зохион байгуулж, гүйцэтгэлд нь хяналт тавин, иргэдэд төрийн үйлчилгээг ил тод, түргэн шуурхай, нээлттэй, тэгш хүртээмжтэй хүргэхэд гол ажлуудыг шийдвэрлэсэн байна.

3.3 Байгууллагын эрсдэлийн удирдлагын тогтолцоо

ТТЗ-ын засаглалын тогтолцооны нэг бүрэлдэхүүн болох эрсдэлийн удирдлагын чиглэлээр удирдлага болон ажилтан албан хаагчид эрсдэлийг тодорхойлох, үнэлэх, удирдах талаар мэдлэг, чадвар дутмаг байна. Эрсдэлийн мэдээллийг цуглуулах, дүн шинжилгээ хийх, шийдвэр гаргалтад ашиглах механизм бүрдээгүй эрсдэлээ бүртгэж үнэлж дүгнэх, хариу арга хэмжээг авахгүй байгаа нь эрсдэлийн удирдлагын тогтолцоо төлөвшөөгүйг илэрхийлж байна.

Иймд эрсдэлийн удирдлагын хэрэгжилтийг хангахтай холбогдуулан дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэн ажиллах шаардлагатай байна. Үүнд:

- *ТТЗ-ын үйл ажиллагаатай холбогдуулан эрсдэлийг /хүний нөөцийн, үйл ажиллагааны, стратегийн, санхүүгийн, нийгэм, засаглалын, мэдээлэл технологийн, зах зээлийн, байгаль орчин, бусад гэх мэт/ ангилан бүртгэх*
- *Эрсдэлийн түшингээр нь бага, дунд, их гэж ангилах замаар эрсдэлийн удирдлагын хариу арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан эрсдэлийг удирдах нөхцөлийг бүрдүүлэн үр дүнг тооцож ажиллах*
- *Эрсдэлийн удирдлагын тогтолцоог төлөвшүүлэх цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг Эрсдэлийн удирдлагын менежментийн ISO 31000 стандарт, MNS ISO 31010:2016 Эрсдэлийн үнэлгээний арга, MNS ISO 31000:2020 Эрсдэлийн менежментийн удирдамжийг үе шаттайгаар нэвтрүүлэх нь зүйтэй.*

3.4 Байгууллагын дотоод хяналтын тогтолцоо

Тус ТТЗ нь дотоод хяналтыг зохион байгуулах төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлж ажилласан байна. Энэ нь Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан "Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-ыг 1.4 дэх заалттай нийцээгүй бөгөөд тус журмын дагуу гүйцэтгэх дотоод хяналтыг зохих удирдамж, төлөвлөгөөний дагуу хийж гүйцэтгээгүй, дүнг тайлагнах үйл явц хангалтгүй байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчид шууд харьяалагдах дотоод хяналтыг хэнээр, хэрхэн хэрэгжүүлэх чиг үүрэг тодорхойгүй, дотоод хяналт шалгалт зохион байгуулах журмыг боловсруулж батлуулаагүйгээс дотоод хяналт сул байна.

Дотоод хяналтын удирдамж, төлөвлөгөөг зөвхөн харьяа нэгжүүд өөрсдийн чиг үүргийн дагуу хийж байгаа нь нэгдсэн удирдлагын тогтолцоо бүрдээгүйг илэрхийлж байна.

ГУРАВ. АУДИТЫН ҮР ДҮН

<u>Илэрсэн асуудал 1</u>	2025 оны эхний хагас жилийн байдлаар орлогын төлөвлөгөөг нийт дүнгээрээ 98.8 хувьтай биелсэн боловч бусад төлбөр хураамж 16.3 хувиар, татварын бус орлогын гүйцэтгэл 38.7 хувиар тус тус дутуу төвлөрүүлсэн байна.
<u>Асуудлын ангилал</u>	Нөлөө их
<p>Бодит байдал: Эхний хагас жилийн байдлаар 413,576.7 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 408,666.4 мянган төгрөгийн буюу 98.8 хувийн биелэлттэй байна. Төлөвлөгөө нэр төрлөөр нь биелэлтийг тулган баталгаажуулахад хөрөнгийн орлого (14,969.3) мянган төгрөгөөр буюу 40.2 хувиар, бууны албан татвар (476.0) мянган төгрөгөөр буюу 39.7 хувиар, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны хураамж (940.0) мянган төгрөгөөр буюу 94.0 хувиар, хог хаягдлын үйлчилгээний хураамж 100.0 мянган төгрөгөөр буюу 100.0 хувиар, газрын төлбөр (11,269.8) мянган төгрөгөөр буюу 53.7 хувиар, ойн нөөц ашигласны төлбөр (24,870.9) мянган төгрөгөөр буюу 13.6 хувиар, торгуулийн орлого 8,696.3 мянган төгрөгөөр буюу 82.4 хувиар, бусад орлого (4,706.8) мянган төгрөгөөр буюу 74.1 хувиар, түрээсийн орлого (369.6) мянган төгрөгөөр буюу 35.2 хувиар тус тус тасарсан байна.</p> <p>Байх ёстой шаардлага /шалгуур/: Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1.-д "Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх"</p> <p>Асуудлын үндсэн шалтгаан: Төсвийн орлогын төлөвлөгөө тасрахад голлон нөлөөлсөн шалтгаан нь тус сумын татварын байцаагч хүүхэд асрах чөлөөтэй байгаа гэх үндэслэлээр орлогын төлөвлөгөөнүүд тасарсан.</p> <p>Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/: Төсвийн орлого бүрэн төвлөрөөгүйгээс шалтгаалан төлөвлөгдсөн зардлуудын санхүүжилтийн эх үүсвэр тасрах. Төрөөс иргэдэд үзүүлэх үйлчилгээний чанар хүртээмж буурах, Хуулиар хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлэхгүй байх</p> <p>Шийдвэр: Төсвийн орлогын бүрдүүлэлтийг ангилал тус бүрээр төлөвлөгөөний дагуу бүрэн төвлөрүүлэх, үр дүнтэй ажил зохион байгуулж ажиллах зөвлөмж хүргүүлэх.</p>	

<u>Илэрсэн асуудал 2</u>	ТТЗ нь "Монгол ЛЗ зам, гүүр" ХХК-тай 2022 онд байгуулсан "ТТАМ-02" дугаартай "Түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглуулах гэрээ"-нд 2024 онд төлөхөөр тооцсон хайрганы төлбөр 215,929.3 мянган төгрөгийг өнөөдрийг хүртэл төвлөрүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлээгүй байна.
<u>Асуудлын ангилал</u>	Нөлөө их
<p>Бодит байдал: Түшиг сумын засаг дарга, Монгол ЛЗ зам, гүүр ХХК-тай 2022 онд байгуулсан ТТАМ-02 дугаартай "Түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглуулах" гэрээний 2.4-т "ТТАМалтмал болох 1 тонн уулын хайргыг 1000 төгрөгөөр тооцно. 538,054 тонн * 1000 төгрөг = 538,054,000 төгрөгийн төлбөрийг Түшиг сумын төрийн сангийн дансны 100131600948 тоот дансанд тушаана. Төлбөрийн санхүүжилтийг доорх хугацаанд, мөнгөн дүнгээр төрийн сангийн дансанд тушаана. 2023 оны 12 сарын 25-ны дотор 269,027,000 /50 хувь/ 2024 оны 06 сарын 30-ны дотор 269,027,000 /50 хувь/ тус тус тушаана" гэсэн боловч 2023 оны 12</p>	

сарын 25-ны өдөр 269,000,000.0 төгрөгийг, 2024 оны 12 сарын 12-ны өдөр 54,124,697.0 төгрөгийг тус тус төвлөрүүлж нийт 215,929,303 төгрөгийг өнөөдрийг хүртэл төвлөрүүлээгүй байна.

Байх ёстой шаардлага /шалгуур/:

Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 33.1-т "Түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь олборлож худалдсан, эсхүл худалдахаар ачуулсан болон ашигласан бүх төрлийн түгээмэл тархацтай ашигт малтмалын бүтээгдэхүүний борлуулалтын үнэлгээнээс тооцож түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг орон нутгийн төсөвт төлнө", Түшиг сумын засаг дарга, Монгол ЛЗ зам, гүүр ХХК-тай 2022 онд байгуулсан ТТАМ-02 дугаартай "Түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглуулах" гэрээний 2.4-т "ТТАМалтмал болох 1 тонн уулын хайргыг 1000 төгрөгөөр тооцно. 538,054 тонн * 1000 төгрөг = 538,054,000 төгрөгийн төлбөрийг Түшиг сумын төрийн сангийн дансны 100131600948 тоот дансанд тушаана. Төлбөрийн санхүүжилтийг доорх хугацаанд, мөнгөн дүнгээр төрийн сангийн дансанд тушаана. ... 2024 оны 06 сарын 30-ны дотор 269,027,000 /50 хувь/ тус тус тушаана.

Асуудлын үндсэн шалтгаан:

ТТЗ нь "Монгол ЛЗ зам, гүүр" ХХК-тай байгуулсан гэрээний 2.4 дэх заалтын хэрэгжилт хангалтгүй, төлбөр төвлөрүүлэх хяналт сул байна. Сумын ЗДТГ болон гэрээт байгууллагын хоорондын гэрээний хэрэгжилтийг хянах, хугацаанд төлбөрийн биелэлт хийхэд шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлээгүй.

Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/:

Орон нутгийн төсөвт орлого бүрэн төвлөрөөгүйгээс төсвийн орлого тасарч, төсөвлөсөн төсөл арга хэмжээ хэрэгжихгүй байх эрсдэлтэй.

Шийдвэр:

Цаашид "Монгол ЛЗ зам, гүүр" ХХК-тай 2022 онд байгуулсан гэрээнд 2024 онд төлөхөөр тооцсон хайрганы төлбөр 215,929.3 мянган төгрөгийг тус сумын Төрийн сангийн түгээмэл тархацтай АМНАТ-ын 100131600948 дугаар дансанд төвлөрүүлэх **төлбөрийн акт** хүргүүлэхээр шийдвэрлэв.

<u>Илэрсэн асуудал 3</u>	Аймгийн ОНХО-аар 2025 онд шинээр хэрэгжүүлэх 140.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй 2 төсөл арга хэмжээ мөн сумын ОНХО-аар хэрэгжүүлэх 164,071.4 мянган төгрөгийн 2 төсөл арга хэмжээ, сумын ОНХС-ын хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх 1,077,569.5 мянган төгрөгөөр 4 арга хэмжээ нийт 1,321,640.9 мянган төгрөгийн 8 төсөл арга хэмжээний төсөв, тооцоо судалгааг урьдчилан хийлгүйгээр ИТХ-р батлуулсан байна.
<u>Асуудлын ангилал</u>	Нөлөө их
Бодит байдал:	Аймгийн ОНХО-аар 2025 онд шинээр хэрэгжүүлэх 80,000.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй 1 төсөл арга хэмжээ, сумын ОНХО-аар хэрэгжүүлэх 164,071.4 мянган төгрөгийн 2 төсөл арга хэмжээ, сумын ОНХС-ын хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх 1,077,569.5 мянган мянган төгрөгөөр 4 арга хэмжээ нийт 1,321,640.9 мянган мянган төгрөгийн 8 төсөл арга хэмжээний төсөв, тооцоо судалгааг урьдчилан хийлгүйгээр ИТХ-р батлуулсан зөрчил илэрлээ. Үүнд: <ul style="list-style-type: none">Аймгийн ОНХО-аар халаалтын төвд зуух худалдан авах 80,000.0 мянган төгрөгийн,

- Сумын ОНХО-аар хэрэгжүүлэх ахуйн үйлчилгээний байрны засвар 109,291.3 мянган төгрөг, нийтийн ахуйн үйлчилгээний барилгын дулааны шугамын өргөтгөл, шинэчлэлийн ажил 54,780.1 мянган төгрөгийн,

Сумын ОНХС-ын хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх Сумын төвийн хатуу хучилттай авто замын засвар, шинэчлэлтийн ажил 753,653.3 мянган төгрөгийн, багийн хэсгийн төв 50,000.0 мянган төгрөгийн, сумын төвийн гэрэлтүүлэг нэмэгдүүлэх 148,247.0 мянган төгрөгийн, нийтийн ахуйн үйлчилгээний барилгын дулааны шугамын өргөтгөл, шинэчлэлийн ажил 125,669.2 мянган төгрөгийн төсөл арга хэмжээнүүд байна.

Эдгээр төсөл, арга хэмжээнүүдийн хэрэгцээ шаардлага, зардлын бодит үндэслэл тодорхойгүй байхад төсөв батлагдсан бөгөөд цаашид хөрөнгө оруулалтын үр өгөөж, гүйцэтгэлийн чанарт сөргөөр нөлөөлөх нөхцөл бүрдүүлээд зогсохгүй, төсвийн хөрөнгийн үр ашиггүй зарцуулалт, санхүүгийн эрсдэл үүсэх нөхцөл бүрдсэн байна.

Байх ёстой шаардлага /шалгуур/:

Төсвийн тухай хуулийн 29.4-т "Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3-т "Улсын болон орон нутгийн төсөв, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөөний жагсаалтад дараах зүйлсийг тусгахыг хориглоно: 13.3.3: "Техник, эдийн засгийн үндэслэл хийгдээгүй, зураг төсөв нь батлагдаагүй, газрын зөвшөөрөл олгогдоогүй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ", Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 4.1.3-т "ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь хуульд заасны дагуу зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэлтэй, байгаль орчны төлөв байдлын үнэлгээ хийгдсэн, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон байх", 4.3.2-т "ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь тухайн орон нутгийн иргэдийн саналаар дэмжигдэж эрэмбэлэгдсэн байх"

Асуудлын үндсэн шалтгаан:

Төсөл, арга хэмжээний зураг, төсвийг ИТХ-р төсөв батлагдсаны дараа хийлгэснээс хөрөнгө оруулалтын үр өгөөж, гүйцэтгэлийн чанарт сөргөөр нөлөөлнө

Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/: Энэ нь төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах, гүйцэтгэлийн чанарт сөргөөр нөлөөлөх, санхүүгийн эрсдэл үүсэх нөхцөлийг бүрдүүлнэ.

Шийдвэр: 2026 онд шинээр хэрэгжүүлэх барилга байгууламж, их засварын төсөл, арга хэмжээний зураг, төсөв, үнийн судалгааг урьдчилан хийж төсөвт тусгуулсан байх **албан шаардлага** хүргүүлэхээр шийдвэрлэв

<u>Илэрсэн асуудал 4</u>	Сумын ОНХС-ийн 2025 оны хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байгаа 100.0 сая төгрөгөөс дээш төсөвт өртөгтэй 3 төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтын баримт бичигт заасан үнийн дүнтэй гүйцэтгэлийн баталгааг захиалагчид хүргүүлээгүй байхад гэрээ байгуулсан байна.
<u>Асуудлын ангилал</u>	Нөлөө бага

Бодит байдал:

Сумын ОНХС-ийн 2025 оны хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй 3 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр гэрээ байгуулсан ч гүйцэтгэгч аж ахуйн нэгжүүдээс хууль, журмын дагуу шаардагдах гүйцэтгэлийн баталгааг гаргуулалгүйгээр ажлыг эхлүүлсэн зөрчил илэрсэн байна. Үүнд:

Аймгийн ОНХС-ын хөрөнгө оруулалтаар Дулааны шугамын шинэчлэл 100,000.0 мянган төгрөгийн төсөл арга хэмжээний 3% буюу 3,000.0 төгрөг

Сумын ОНХС-ын хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх сумын төвийн гэрэлтүүлэг нэмэгдүүлэх 118,597.6 мянган төгрөгийн төсөл арга хэмжээний 3% буюу 3,557.9 төгрөг,

Малын үүлдэр угсаа сайжруулж, үржил цөм сүрэг бүрдүүлэх 130,000.0 мянган төгрөгийн төсөл арга хэмжээний 3% буюу 3,900.0 төгрөгийн, нийт 10,457.9 мянган төгрөгийн гүйцэтгэлийн баталгааг гэрээ байгуулсан байгууллагаар гаргуулаагүй байгаа нь тухайн байгууллагад гэрээний үүргээ биелүүлэх хөшүүрэг, хариуцлага үүрүүлэх нөхцөл боломж бүрдүүлээгүй байна.

Байх ёстой шаардлага /шалгуур/:

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-д "Тендер шалгаруулалтын төсөвт өртөг 100 сая төгрөгөөс дээш бол гэрээний үүргийн биелэлтийг баталгаажуулах зорилгоор гүйцэтгэлийн баталгаа шаардана", Сангийн сайдын 2023 оны А/252 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Худалдан авах ажиллагаанд баталгаа гаргах, орлого болгох журам"-ын 3.1 дэх "Хуулийн 42.1-д зааснаас дээш төсөвт өртөгтэй тендер шалгаруулалтад гэрээ байгуулах эрх авсан оролцогч тендер шалгаруулалтын баримт бичигт зааснаас багагүй үнийн дүнтэй гүйцэтгэлийн баталгааг захиалагчид хүргүүлнэ"

Асуудлын үндсэн шалтгаан:

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллаагүй. Дотоод хяналт сул

Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/:

Тухайн байгууллага гэрээний үүргээ биелүүлэхгүй байх эрсдэлтэй, мөн холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилт хангагдахгүй байх.

Шийдвэр: 2026 онд шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээний гэрээ байгуулах зөвшөөрөл авсан аж ахуйн нэгж байгууллагаар гүйцэтгэлийн баталгааг гаргуулан гэрээг байгуулах албан шаардлага хүргүүлэх.

<u>Илэрсэн асуудал 5</u>	Тус газраас 2024 онд "17 сумын хоршоог хөгжүүлэх сангийн үйл ажиллагааны үр дүн"-д хийсэн аудитаар өгсөн 2 албан шаардлага, 1 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй зөрчил илэрлээ
<u>Асуудлын ангилал</u>	Нөлөө их
Бодит байдал:	
Зээлийн мэдээллийн нэгдсэн сангийн үлдэгдэл, санхүүгийн тайлангаас зөрүүтэй	
<ul style="list-style-type: none">ХХС-ийн зээлийн мэдээллийн нэгдсэн сангийн үлдэгдэл, санхүүгийн тайлангийн дүнгээс 2024 онд 19,471.1 мянган төгрөг, 2025 онд 17,953.5 мянган төгрөгөөр зөрүүтэй байна. Харилцагч тус бүрээр авлагын дүнг тулган баталгаажуулж бүртгэлийн зөрүүг залруулах.	
Зээлдэгчдийн авлагын бүртгэл буруу, үлдэгдлийг баталгаажуулаагүй	
<ul style="list-style-type: none">Санхүүгийн тайлангийн программд 22 зээлдэгчийн авлагыг бөөн дүнгээр бүртгэсэн.Авлага, төлбөрийн тооцоог тус бүрээр нь хянаж баталгаажуулаагүй нь авлагын мэдээллийн үнэн зөв, найдвартайд эргэлзээ төрүүлж байна. Санхүүгийн программд харилцагч тус бүрээр тооцоо нийлж баталгаажуулсан дүнгээр зээлийн мэдээллийн нэгдсэн сангийн дүнтэй тааруулж авлагын бүртгэлийг харилцагч тус бүрээр задалж бүртгэх	

Зээлийн эргэн төлөлтийн хяналт сул

- ХХС-ийн зээлийн эргэн төлөлтөд зохих журмын дагуу хяналт тавиагүйгээс 10 зээлдэгч нийт **32,179.5 мянган төгрөгийн** үлдэгдэлтэйгээр чанаргүй зээлийн ангилалд орсон. Журмын 7.1-д заасан Сангийн хөрөнгийн зарцуулалт, үйл ажиллагааны үр дүнгийн зохистой харьцааны шалгуур үзүүлэлтэд заасан зээлийн эргэн төлөлтийн шалгуурыг хангуулахад хяналт тавин ажиллах

Хөрөнгийн зохистой харьцаа хангагдаагүй

- Тайлант онд сангийн нийт хөрөнгийн 30-аас доошгүй хувийг бүрдүүлэх ёстой ч 2024 онд **28.6%**, 2025 оны эхний хагас жилийн байдлаар ердөө **4.1%** байна.
- Энэ нь сангийн тогтвортой үйл ажиллагаа, хөрөнгийн чадавхад эрсдэл үүсгэсэн.

ХХС-ийн эх үүсвэрийн хөрөнгө бэлтгэж бүртгэгдсэн

- ХХС-ийн эх үүсвэрээр хөрөнгө бэлтгэсэн боловч санхүүгийн тайланд хөрөнгөөр бүртгэсэн байна.
- Энэ нь хууль тогтоомжид нийцээгүй, санхүүгийн тайлан мэдээ буруу илэрхийлэгдсэн зөрчил юм.

Зээлийн гэрээ үрэгдсэн

- 2 зээлдэгчийн зээлийн гэрээ үрэгдсэн тул тэдгээрийг хууль ёсны дагуу шүүхэд өгөх боломжгүй болсон.
- Үүний улмаас авлага эргэн төлөгдөөгүй, сангийн хөрөнгийн алдагдалд хүргэсэн.

2025 онд ХХС-аас "Туж өгөөмөр" хоршоонд олгосон зээлийн барьцаа хөрөнгийг дутуу үнэлсэн

Байх ёстой шаардлага /шалгуур/:

Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх "Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ." гэсэн заалтыг зөрчсөн байна.

Асуудлын үндсэн шалтгаан:

Өмнөх аудитаар өгсөн зөрчил дутагдлыг давтан гаргасан, дотоод хяналт шалгалтыг хэрэгжүүлээгүйгээс голлон шалтгаалсан

Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/:

Сангийн хөрөнгө бүрэн төвлөрөхгүй байх, санхүүгийн тайлан мэдээ буруу илэрхийлэгдэх,

Шийдвэр: Улсын байцаагчийн өмнөх аудитын шаардлагыг арилгаагүй, давтан гаргасан буруутай албан тушаалтанд хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцох. албан шаардлага хүргүүлэх.

<u>Илэрсэн асуудал 6</u>	ХХС-аас 2025 онд "Туж өгөөмөр" хоршоонд 35,000.0 мянган төгрөгийн зээлийг олгохдоо барьцаа хөрөнгийн үнэлгээгүйгээр зээл олгосон байна.
<u>Асуудлын ангилал</u>	Нөлөө их
Бодит байдал: 2025 онд ХХС-аас "Туж өгөөмөр" хоршоонд 35,000.0 мянган төгрөгийн зээл олгохдоо Г-1312000200 дугаартай 2502 мкв газар, Y1312000154 дугаар бүхий 58 мкв хувийн орон сууцны зах зээлийн үнэлгээг тогтоолгүй зээлдэгчийн үнэлсэн үнэлгээгээр барьцаалан зээл олгосон байна. 58 мкв хувийн орон сууцыг 90%-ийн гүйцэтгэлтэй байхад 2014 онд Улсын бүртгэлд бүртгүүлж Y1312000154 дугаар бүхий гэрчилгээг авсан бөгөөд уг гэрчилгээг шинэчлээгүй, барьцаа хөрөнгийн шаардлага хангаагүй байхад сангаас зээл олгосон байна	
Байх ёстой шаардлага /шалгуур/: Хоршооны тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1.9-д "Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журмыг батлах, уг сангийн зарцуулалтад хяналт тавих, нэгдсэн бодлого, удирдлагаар хангах", ХХААС-ын 2021 оны А/361 дүгээр тушаалаар батлагдсан "Хоршоог хөгжүүлэх сангаас	

хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам"-ын 3 дугаар зүйлийн 3.4.4-т .энэ журмын 3.4.3-т заасны дагуу зээлийн болон барьцааны гэрээ байгуулахдаа барьцаалах үл хөдлөх хөрөнгийн үнэлгээг тогтоох чиг үүрэг бүхий ажлын хэсэг байгуулан дүгнэлт гаргуулах ...; 6.3.3-д "зээлийн хөрөнгийг зориулалтын дагуу ашиглаж, хугацаанд нь төлөх төлбөрийн чадвартай, барьцаа хөрөнгөтэй байх", 6.4.4-д "төслийн зээлийн мөнгөн дүнд хүрэлцэхүйц барьцаа хөрөнгөтэй байх"

Асуудлын үндсэн шалтгаан:

ХХААС-ын 2021 оны А/361 дүгээр тушаалаар батлагдсан "Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам"-ыг хэрэгжүүлээгүйгээс шалтгаалсан.

Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/:

Зээлдэгч зээлийн гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд зээлийн үлдэгдлийг барьцаа хөрөнгөөр хангуулах боломжгүй болно. Сангийн хөрөнгийг алдагдалд оруулах хугацаа хэтэрсэн зээлийг хууль хяналтын байгууллагад шилжүүлэн шүүхийн шийдвэрээр албадан төлүүлэх боломжгүй сөрөг үр дагавартай

Шийдвэр: Цаашид барьцаа хөрөнгийн үнэлгээг бодитоор үнэлж шалгуур хангасан тохиолдолд зээл олгож байх зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв.

ДӨРӨВ. НЭГДСЭН ДҮГНЭЛТ

Төсвийн ерөнхийлөн захирагчийн дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын газраас Түшиг сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн үйл ажиллагаанд холбогдох хууль тогтоомжийн дагуу дотоод аудитыг хийж гүйцэтгэхэд илэрсэн алдаа зөрчлийг үндэслэн "Сайжруулах шаардлагатай" гэсэн дүгнэлтийг өгч байна.

Байгууллага өөрийн зорилгодоо хүрэхийн тулд эрсдэлийн удирдлагын хэрэгжүүлэн, дотоод хяналтыг үр нөлөөг сайжруулах тогтолцоог бий болгож шийдвэр гаргалтад түүнийг үр дүнтэй ашиглаж хэвших шаардлагатай байна.

Дүгнэлтийн төрөл	Дүгнэлтийн тайлбар
Сайжруулах шаардлагатай	Байгууллагын засаглал, эрсдэлийн удирдлага болон дотоод хяналтын үйл явцын төлөвшил нь "давтамжтай буюу 1-р түвшин"-д байна гэж үзсэн. Аудитаар илэрсэн асуудлуудын 66.7% нь "нөлөө ихтэй" гэж үзсэн

ТАЙЛАН БЭЛТГЭСЭН
ДОТООД АУДИТОР

Г.ДОРЖДЭРЭМ

ТАЙЛАН ХЯНАСАН
ДАРГА, СХШУАБ

Т.ОДСҮРЭН

ТАНИЛЦСАН:
ТҮШИГ СУМЫН ЗАСАГ ДАРГА

Н.БАРАМСАЙ

ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ

Б.БАТДЭЛГЭР

